

TENGER 03/26



WEB

Vítejte u třetího vydání našeho newsletteru, který nově ponese název TENGER – prostor pro sdílení novinek, inspirace a propojení česko-mongolské komunity.

Tentokrát přinášíme rozhovor s MUDr. Selenge Koupovou, informace o aplikaci od Batbayar „Baji“ Nyambayara pro psaní mongolské cyrilice na běžné klávesnici. Najdete zde také přehled plánovaných akcí naší společnosti a další užitečné odkazy. Příjemné čtení Vám přeje Jana Uher.

Манай мэдээллийн товхимлын гурав дахь дугаарт тавтай морилно уу. Энэ удаагаас эхлэн манай товхимол **Tenger** нэртэйгээр хүрэх бөгөөд энэ нь мэдээ мэдээлэл, урам зориг, Чех-Монголын хамтын нийгэмлэгийг холбох орон зай байх болно.

Энэ удаад бид та бүхэнд АУ-ны доктор Сэлэнгэ Коуповатай хийсэн ярилцлага, Батбаярын “Бажи” Нямбаярын энгийн гар дээр монгол кириллээр бичих боломжтой аппликейшний тухай мэдээллийг хүргэж

байна. Мөн манай нийгэмлэгийн төлөвлөсөн арга хэмжээнүүдийн тойм болон хэрэгтэй холбоосуудыг эндээс олж болно. Та бүхэндээ таатай уншлагыг хүсэн ерөөе.

Яна Ухер.

Následující text vznikl z rozhovoru s dr. Koupovou.

Дараах текст нь доктор Коуповатайт хийсэн ярилцлагаас бүтсэн болно.

S pokorou a respektem: životní cesta MUDr. Selenge Koupové

Tento medailonek vznikl na základě e-mailové komunikace mezi námi a paní doktorkou Selenge Koupovou. Odpovědi na naše otázky nám poskytla písemně, díky čemuž můžeme přiblížit její životní příběh, profesní cestu i osobní pohled na život mezi Mongolskem a Českou republikou.

MUDr. Selenge Koupová pochází z Mongolska, ale v České republice žije už téměř 28 let. Její životní cesta sem ale nebyla přímočará. Po dokončení střední školy v západomongolském městě Chovd toužila studovat medicínu, ale napoprvé se na univerzitu bohužel nedostala. Plánovala se připravit na přijímací zkoušky v dalším roce, když ji její starší sestra, která tehdy pracovala jako farmaceutka v Praze, pozvala na návštěvu. Původně přijela na tříměsíční turistické vízum, ale nakonec se rozhodla zůstat a studovat medicínu v ČR.

Začátky v nové zemi pro ni nebyly jednoduché. Největší překážkou byla jazyková bariéra a s ní spojená nedorozumění. Naopak příjemně ji překvapila pražská dopravní infrastruktura a její spolehlivost. Vše fungovalo přesně a načas.

I po letech strávených v Česku jí některé věci z domova chybí. Především samozřejmě postrádá rodinu, ale také mongolskou přírodu a specifické mongolské podnebí. Mongolsko podle ní stojí za bližší poznání i díky svým lidem, kteří jsou podle ní velmi pohostinní a pracovití.

Velkou roli v jejím životě hraje pokora. Věří, že člověk by měl přistupovat ke všem lidem se stejným respektem – bez ohledu na jejich postavení. Stejnou úctu si zaslouží uklízečka i významná osobnost.

Specializaci si vybrala v oboru anesteziologie, který ji zaujal svou dynamičností. Oceňuje, že jde o „akční“ a velmi specifický obor, kde je potřeba nejen odborných znalostí, ale i manuální zručnosti a rychlého rozhodování.

Při srovnání zdravotnictví v Česku a Mongolsku zdůrazňuje, že nemá úplně aktuální přehled o situaci ve své rodné zemi, ale vnímá, že tamní systém je více ovlivněn finanční stránkou. České zdravotnictví považuje za velmi kvalitní, zejména díky dostupnosti péče a odborných vyšetření. I zde však vidí prostor pro zlepšení, například v nadměrném využívání pohotovostních služeb.

Mladým Mongolům žijícím v zahraničí by doporučila především věnovat čas studiu jazyka dané země, protože to zásadně ovlivňuje pracovní i osobní život. Zároveň zdůrazňuje význam sebevzdělávání a smysluplného využití času.

Silný moment ve své profesní dráze zažila, když si na ni po osmi letech vzpomněl jeden z pacientů a přišel ji znovu požádat, aby ho uspala při dalším zákroku. Tento projev důvěry ji velmi potěšil a utvrdil v tom, že její práce má smysl.

Pro MUDr. Koupovou znamená péče především lidský přístup. Každému pacientovi se snaží věnovat individuálně a s respektem, aby se cítil co nejklidněji a nejpříjemněji před zákrokem. Právě empatie a lidskost jsou podle ní základem kvalitní medicíny.

Даруу байдал ба хүндэтгэлтэйгээр: АУ-ны доктор Сэги Коуповагийн амьдралын замнал

Энэхүү танилцуулга нь бид болон доктор Сэги Коупова нарын хооронд болсон имэйлийн харилцаанд тулгуурлан бэлтгэгдсэн болно. Тэрээр бидний асуултад бичгээр хариулсан бөгөөд үүний ачаар бид түүний амьдралын түүх, мэргэжлийн замнал, мөн Монгол болон Чех улсын хоорондох амьдралын талаарх хувийн үзэл бодлыг нь хүргэж байна.

АУ-ны доктор Сэги Коупова нь Монгол Улсаас гаралтай боловч Чех улсад бараг 28 жилийн турш амьдарч байна. Гэвч түүний энэ замнал

шулуун дардан байгаагүй. Тэрээр баруун Монголын Ховд хотод дунд сургуулиа төгсөөд анагаах ухаан сурах хүсэлтэй байсан ч анхны оролдлогоор их сургуульд элсэж чадаагүй. Дараа жил элсэлтийн шалгалтад бэлтгэхээр төлөвлөж байх үед Прага хотод эм зүйчээр ажиллаж байсан эгч нь түүнийг зочлохыг урьжээ. Тэрээр анх гурван сарын жуулчны визээр ирсэн ч эцэст нь Чех улсад үлдэж, анагаах ухаан сурахаар шийдсэн байна.

Шинэ оронд эхлэл амар байгаагүй. Хамгийн том бэрхшээл нь хэлний саад, түүнээс үүдэлтэй үл ойлголцол байсан. Харин Прага хотын тээврийн дэд бүтэц, найдвартай байдал нь түүнийг эерэгээр гайхшруулжээ. Бүх зүйл цагтаа, нарийн зохион байгуулалттай ажилладаг байсан.

Чех улсад олон жил амьдарсан ч түүнд эх орных нь зарим зүйлс үгүйлэгдсээр байдаг. Юуны өмнө мэдээж гэр бүлээ, мөн Монголын онгон байгаль, өвөрмөц уур амьсгалыг санагалздаг. Түүний хэлснээр Монгол Улс нь хүмүүсийнхээ ачаар илүү ойроос танин мэдэх үнэ цэнтэй орон бөгөөд монголчууд маш зочломтгой, хөдөлмөрч хүмүүс юм.

Түүний амьдралд даруу байдал чухал байр суурь эзэлдэг. Тэрээр хүн бүрт, ямар ч албан тушаалтай байсан ялгалгүй, ижил хүндэтгэлтэй хандах ёстой гэж үздэг. Цэвэрлэгч ч бай, нэр хүндтэй хүн ч бай адилхан хүндлэл хүртэх ёстой.

Тэрээр мэргэжлээрээ мэдээгүйжүүлгийн (анестезиологийн) чиглэлийг сонгосон нь түүний сонирхлыг хөдөлгөсөн, идэвхтэй, онцлогтой салбар юм. Энэ мэргэжил нь зөвхөн онолын мэдлэгээс гадна гарын ур дүй, түргэн шийдвэр гаргах чадварыг шаарддаг гэдгийг онцолдог.

Чех болон Монголын эрүүл мэндийн тогтолцоог харьцуулахдаа эх орныхоо өнөөгийн нөхцөл байдлын талаар бүрэн мэдээлэлгүй ч Монголд эрүүл мэндийн салбар санхүүгийн нөлөөнд илүү автсан мэт санагддаг гэж хэлжээ. Харин Чехийн эрүүл мэндийн тогтолцоог чанартай, ялангуяа үйлчилгээний хүртээмж, нарийн мэргэжлийн үзлэгийн боломж сайтай гэж үнэлдэг. Гэсэн хэдий ч яаралтай тусламжийг хэт ашиглах зэрэг сайжруулах шаардлагатай талууд байгааг мөн дурдсан.

Гадаадад амьдарч буй залуу монголчуудад тэрээр тухайн орны хэл сурахад анхаарахыг зөвлөж байна. Учир нь хэлний мэдлэг нь ажил, хувийн амьдралд шийдвэрлэх нөлөөтэй. Мөн өөрийгөө хөгжүүлэх, цагийг үр бүтээлтэй ашиглахын чухлыг онцолжээ.

Түүний мэргэжлийн замналд тод үлдсэн нэгэн мөч бол найман жилийн дараа нэг өвчтөн нь түүнийг санан, дахин мэдээ алдуулахыг хүсэж ирсэн явдал байв. Энэ нь итгэл хүлээлгэсэн томоохон дохио болж, түүний ажлын утга учрыг улам баталгаажуулжээ.

АУ-ны доктор Коуповагийн хувьд "асаргаа, халамж" гэдэг нь юуны өмнө хүний хандлага юм. Тэрээр өвчтөн бүрт хувь хүнчилсэн, хүндэтгэлтэй хандаж, эмчилгээний өмнө аль болох тайван, тухтай байлгахыг хичээдэг. Түүний бодлоор энэрэнгүй сэтгэл, хүнлэг чанар нь чанартай анагаах ухааны үндэс юм.



Bichig.mn: Moderní nástroje pro snadné psaní mongolsky

Projekt Bichig.mn od vývojáře Batbayara „Baji“ Nyambayara usnadňuje psaní mongolštiny v digitálním světě – bez nutnosti učit se složité rozložení klávesnice. Systém automaticky převádí text psaný latinkou do správné mongolské cyrilice, opravuje pravopis a průběžně ukládá rozepsané texty, aby se nic neztratilo.

Bichig.mn není jen překladač, ale moderní psací studio s možností formátování textu, vlastním úsporným formátem dokumentů „.bichig“ a podporou pro počítače i telefony. Součástí projektu je také rozšíření pro Chrome a chytrá Android klávesnice, kterou si uživatelé mohou stáhnout za malý poplatek v obchodě Google Play.

Projekt myslí i na budoucnost staromongolského písma. Nabízí nástroje pro převod mezi cyrilicí a staromongolštinou a pomáhá zpřístupnit tradiční texty širší veřejnosti.

Cílem projektu je propojit moderní technologie s mongolským jazykem a umožnit lidem po celém světě psát mongolsky přirozeně, jednoduše a bez technických bariér.

Vyzkoušejte si Bichig.mn sami a objevte, jak snadné může být psaní mongolsky na počítači i telefonu – ať už žijete kdekoli na světě.

Bichig.mn: Монгол хэлээр хялбар бичих орчин үеийн хэрэгслүүд

Хөгжүүлэгч Батбаярын “Бажи” Нямбаярын бүтээсэн Bichig.mn төсөл нь монгол хэлийг дижитал орчинд хялбар бичих боломжийг олгодог бөгөөд хэрэглэгчид төвөгтэй гарын байрлал сурах шаардлагагүй юм. Энэхүү систем нь латин үсгээр бичсэн текстийг автоматаар зөв монгол кирилл рүү хөрвүүлж, зөв бичгийн алдааг засахын зэрэгцээ бичиж буй текстуг тасралтгүй хадгалдаг тул мэдээлэл алдагдахгүй.

Bichig.mn нь зөвхөн хөрвүүлэгч биш бөгөөд текст форматлах боломжтой орчин үеийн бичгийн студи юм. Мөн “.bichig” нэртэй өөрийн хөнгөн файлын форматтай бөгөөд компьютер болон гар утсан дээр ашиглах боломжтой. Төслийн хүрээнд Chrome өргөтгөл болон Android үйлдлийн системд зориулсан ухаалаг гарын аппликейшн бий бөгөөд хэрэглэгчид Google Play дэлгүүрээс бага хэмжээний төлбөрөөр татан авах боломжтой.

Төсөл нь уламжлалт монгол бичгийн ирээдүйд ч анхаарч байна. Кирилл болон уламжлалт монгол бичгийн хооронд хөрвүүлэх хэрэгслүүдийг санал болгож, уламжлалт эх сурвалжуудыг илүү өргөн хүрээнд ашиглах боломжийг бүрдүүлж байна.

Төслийн зорилго нь орчин үеийн технологийг монгол хэлтэй холбож, дэлхийн хаана ч амьдарч буй хүмүүст монгол хэлээр байгалийн мэт хялбар, саадгүй бичих боломжийг олгоход оршино.

Та Bichig.mn-ийг өөрөө туршиж үзээд компьютер болон гар утсан дээр монгол хэлээр бичих ямар хялбар болохыг мэдрээрэй — дэлхийн хаана ч байсан хамаагүй.

The advertisement features a woman in a black traditional Mongolian dress sitting at a wooden table in a library, typing on a laptop. A semi-transparent software interface for the 'Bichig.mn keyboard' is overlaid on the left side of the image. The interface includes the following elements:

- Logo:** A stylized 'B' with a feather, accompanied by the text 'BICHIG.MN'.
- Title:** 'Bichig.mn keyboard' with a subtitle 'Латинаас Кирилл рүү хөрвүүлэгч / Latin to Cyrillic Mongolian Keyboard'.
- Section: БИЧИХ ГОРИМ (Writing Mode)**
 - Cyrillic Input:** 'Латинаас кирилл рүү хөрвүүлэх / Alt + Shift + M' with a toggle switch.
 - Vowel Harmony:** 'Эгшиг зохицох дүрмээр бичих / Alt + Shift + H' with a toggle switch.
- Section: ХАРАГДАХ БАЙДАЛ (Appearance)**
 - Show Keyboard UI:** 'Далгачан дээр гар харуулах' with a toggle switch.
 - Reset UI:** 'Гарны байршил, хэмжээг шинэчлэх'.
- Buttons:** 'Bichig.mn' and 'Donate / Support'.
- Footer:** 'Rate us on Web Store ★' and 'bichig.mn'.

On the far left, large white and yellow text reads 'БИД ШИНЭ UI ТАЙ БОЛЛОО'. In the bottom right corner of the image, the 'BICHIG.MN' logo is repeated.

Бичихэд таатай. Шинэ орон зай

The screenshot displays the Bichig.MN editor interface. The top header features the Bichig.MN logo and the text "Бичихэд таатай. Шинэ орон зай". The main editor area shows a text document with Mongolian text and a rich text editor toolbar. The sidebar on the left contains navigation options: "Кириллээр бичих" (Write in Cyrillic), "Browser Extension", "Монголоор бичих" (Write in Mongolian) with a "BETA" badge, "Help & Contact", "Terms of Use", and "Privacy Policy". At the bottom of the sidebar, it says "CREATED BY Batbayar Nyambayar" and includes "Dark Theme" and "Share App" buttons. The editor toolbar includes options for font style (Normal), font size (24), and text formatting (Bold, Italic, Underline, Strikethrough). The text in the editor is written in a stylized font and includes the following Mongolian text:

бадаг:
Вм Г# Вм
Үүдэнд чинь ирээд буцлаа хайрт минь,
Г а Д Вм
Үймрүүлж чамайгаа орхих юм шиг санагдаад буцлаа.
Em а Д Вм
Зөвлөн инээмсэглээд, гараад ирхийг чинь төсөөлөвч,
Em Г# Вм Г#7
Зурх зориг минь энд хүрээд буцлаа..
Вм Г# Вм
Босгонд чинь тугаад зогслоо хайрт минь,
Г а Д Вм
Бодол болгож чамайг үлдээх юм шиг санагдаад буцлаа..
Em а Д Вм
Хаалгыг чинь тогших гэснээ больж,
Em Г#m Вм Г#7
Халаасандаа гараа шургуулаад ирэгтээ...

At the bottom of the editor, there is a status bar showing "Current Letter: - Cyrillic: - Input: -" and "Bichig.MN: latin to Cyrillic Mongolian editor". On the right side, there is a page indicator "Page 1/3" and a zoom level of "100%".

Шинэчлэгдсэн
Bichig.mn редактор.

9. 6. 2026

12-21³⁰

**SLYŠÍM
VIDÍM
CHUTNÁM
SVĚT**



STREET FOOD FESTIVAL Z CELÉHO SVĚTA

PŘÍMO NA METRU C STANICE LÁDVI

Bohatý program pro celou rodinu plný lahodných chutí,
podmanivých tónů a pestrého tvoření

K POSLECHU A TANCI

VANUA2 (VU/CZ)

PRAGASON + ŠKOLA SALSY (CU/UY/PA/CZ)

JOYFUL (CZ)

GEREGE (MN)

SBOR FRIENDS SCHOOL (UA)

DJ GRUU (CZ)

DOPROVODNÝ PROGRAM

Studenti z Perrott Hill British School Prague:

prezentace zemí z celého světa

Dále workshopy, pouliční divadlo, cestovatelské přednášky,
malování henou, pletení copánků a dlaší

**MEZINÁRODNÍ
Den dětí**

DÍLNY PRO DĚTI 14-19⁰⁰

Dílny pro děti: malování, hry ze všech koutů světa.

Změna programu vyhrazena. Z akce bude pořízena foto a video dokumentace, která může být zveřejněna.
Projekt je realizován s finanční podporou hlavního města Prahy a městské části Prahy 8.



**Městská část
Praha 8**



**Perrott Hill
BRITISH SCHOOL - PRAGUE**



Městská knihovna v Praze



POZVÁNKY

V nadcházejících měsících nás čeká řada kulturních, komunitních a vzdělávacích akcí, jejichž cílem je přibližovat mongolskou kulturu široké veřejnosti a vytvářet prostor pro setkávání, sdílení a vzájemnou spolupráci.

Dne 9. června se zúčastníme festivalu „**Slyším, vidím, chutnám svět**“, pořádaného městskou částí Praha 8, Kulturním domem Ládví a Magistrátem hlavního města Prahy. Kromě našeho stánku a aktivit pro děti zde budeme představovat činnost naší organizace. Zároveň jsme pomohli zprostředkovat také účast a vystoupení dalších zástupců mongolské komunity.

Srdečně vás zveme i na naše další připravované akce. Dne 7. července proběhne v našich prostorách ve Svídnické ulici **Setkání přátel Mongolska**.

Dne 11. července se uskuteční **Den mongolské kultury v ZOO Praha**, kde budeme mít rovněž své zázemí u Vzdělávacího centra. Budeme moc rádi, když nás přijdete navštívit v době od 10 do 16 hodin. Více o celé akci se brzy dozvíte na našem webu a facebooku.

Na konci srpna se bude konat **přednáška dr. Šímy** věnovaná jeho prvním cestám do Mongolska. V září pak připravujeme **workshop hrdečního zpěvu**. Pro aktuality sledujte náš [facebook:-\)](#)

Věříme, že nás v druhé polovině roku čeká ještě mnoho dalších zajímavých setkání a akcí, které budou dále rozvíjet česko-mongolské vztahy i komunitní život.

УРЬДЧИЛСАН УРИЛГУУД

Ирэх саруудад биднийг Монголын соёлыг олон нийтэд таниулах, уулзалт, харилцаа, хамтын ажиллагааны орон зайг бүрдүүлэх зорилготой олон соёлын, олон нийтийн болон боловсролын арга хэмжээнүүд хүлээж байна.

6-р сарын 9-нд Прага 8 дүүрэг, Ладви соёлын төв болон Прага хотын захиргаанаас зохион байгуулж буй “Сонсьё, харъя, амталъя дэлхийг” фестивалд оролцоно. Манай байгууллага өөрийн үйл ажиллагааг танилцуулахаас гадна хүүхдүүдэд зориулсан үйл ажиллагаа бүхий асартай оролцоно. Мөн Монголын хамтын нийгэмлэгийн бусад төлөөлөгчдийн оролцоо, тоглолтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн.

Мөн та бүхнийг бидний дараагийн арга хэмжээнүүдэд урьж байна. 7-р сарын 7-нд Свидница дахь манай байранд “Монголын найзуудын уулзалт” болно.

7-р сарын 11-ний өдөр Prague Zoo-д Монголын соёлын өдөрлөг зохион байгуулагдана. Энэ үеэр бид мөн боловсролын төвийн дэргэд өөрсдийн танилцуулгын хэсэгтэй оролцоно. Та бүхнийг 10:00–16:00 цагийн хооронд хүрэлцэн ирж, бидэнтэй уулзахыг чин сэтгэлээсээ урьж байна. Арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тун удахгүй манай вэбсайт болон Facebook хуудсаас авах боломжтой болно.

8-р сарын сүүлээр доктор Шимагийн Монголд хийсэн анхны аяллуудад зориулсан лекц зохион байгуулагдана. Харин 9-р сард хөөмийн workshop буюу сургалт бэлтгэж байна. Шинэ мэдээллүүдийг манай Facebook хуудсаар дагаарай :-)

Оны хоёрдугаар хагаст Чех-Монголын харилцаа болон хамтын нийгэмлэгийн амьдралыг улам хөгжүүлэх олон сонирхолтой уулзалт, арга хэмжээ биднийг хүлээж байна гэдэгт итгэлтэй байна.



3. SETKÁNÍ PŘÁTEL MONGOLSKA

Srdečně vás zveme na přátelské setkání všech, kteří v Mongolsku žili, pracovali, studovali nebo tam pobývali třeba jen část svého života spolu se svými rodiči či blízkými.

Rádi bychom vytvořili prostor pro společné vzpomínání, sdílení příběhů, fotografií a zážitků, pro navázání na stará přátelství i vznik nových kontaktů mezi lidmi, které spojuje vztah k Mongolsku.

Čeká nás neformální a přátelské odpoledne u malého občerstvení. Pokud máte, přineste i své mongolské speciality.

Budeme moc rádi, když přijдете mezi nás, a pokud víte o někom dalším, koho by toto setkání mohlo potěšit, budeme rádi za sdílení pozvánky.

Plánujete přijít? Dejte nám vědět.

Napište nám na info@czechmongol.cz, nebo zavolejte na 721 945 139.

Těšíme se na společné setkání a vzpomínky na Mongolsko.

Kdy: **7. července 2026**
V kolik: **13:00 - 15:00**
Kde: **Svidnická 506/1, Praha 8**



**Vstup brankou vpravo
před hlavním vchodem**

- Zastávka autobusu 177 a 144
Poliklinika Mazurská
- Parkování v okolních ulicích
zdarma



Společnost česko-mongolského
přátelství a spolupráce

Pro další akce sledujte náš web a facebook
www.czechmongol.cz
www.mongolspace.com

Znáte někoho, kdo studoval v ČR a nyní žije a pracuje v Mongolsku? Pak by ho či ji mohla zajímat tato akce: Alumni Meetup Mongolia 2026

Танд Чех улсад суралцаж байсан бөгөөд одоо Монголд ажиллаж, амьдарч буй хүн танил бий юу? Тэгвэл тэдэнд "Alumni MeetUp Mongolia 2026" арга хэмжээ сонирхолтой байж магадгүй юм.



MONGOLSKÝ HRDELNÍ ZPĚV

Vždy vás fascinoval mongolský hrdelní zpěv?

Přijďte si ho vyzkoušet na vlastní hlas!

Tento workshop je určen úplným začátečníkům, kteří chtějí proniknout do tajů tradičních vokálních technik Střední Asie.

Není potřeba žádná předchozí zkušenost – stačí chuť objevovat možnosti vlastního hlasu.

Program zahrnuje:

- ukázky mongolského hrdelního zpěvu
- základy bráničního dýchání
- techniky zesílení hlasu
- základní alikvotní modulace samohlásek U, A, O, E, I
- úvod do stylu kargyraa
- práci s řadou harmonických tónů a jejich fixací

Workshopem vás provede zpěvák mongolské kapely Gerege - **Hosoo Hosoo**, který vám krok za krokem představí základy této jedinečné vokální tradice.

Příklad do angličtiny i češtiny zajištěn.


Kdy: **19. září 2026**
V kolik: **9:30 - 12:30**
Kde: **Svídnická 506
Praha 8**

Cena: 800,-

Počet míst omezen!

Plánujete přijít? Dejte nám vědět.

Registrujte se na info@czechmongol.cz



Svídnická 506/1 (Address) • [Mapy.com](https://www.mongospace.com)



Společnost česko-mongolského přátelství a spolupráce

Pro další akce sledujte náš web a facebook
www.czechmongol.cz
www.mongospace.com

Chcete se (nejen přes léto) zdokonalit v českém jazyce nebo mongolštině? Jste úplní začátečníci nebo si chcete zlepšit úroveň konverzací? Ozvěte se nám. Budeme otvírat kurzy pro oba jazyky.

info@czechmongol.cz

Та зуны хугацаанд чех эсвэл монгол хэлээ сайжруулахыг хүсэж байна уу? Та анхан шатны суралцагч эсвэл ярианы чадвараа дээшлүүлэхийг хүсэж байгаа хүн байж болно.

Бид хоёр хэлний сургалтыг шинээр нээх гэж байгаа тул бидэнтэй холбогдоорой. info@czechmongol.cz

**Společnost česko-mongolského
přátelství a spolupráce**

Klimentská 1246, Praha
Czech Republic



www.czechmongol.cz

www.mongolSPACE.com

[Unsubscribe](#)

